

ҮНДЭСТЭН ДАМНАСАН КОРПОРАЦИ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ҮНДСЭН ОРОЛЦОГЧ БОЛОХ НЬ

П.Мягмардорж*

Өнөөгийн олон улсын харилцааны /ОУХ/ судлаачдын дунд ямар субъектийг олон улсын харилцааны үндсэн оролцогч хэмээн үзэх талаар тодорхой байр суурийн зөрчил хадгалагдсаар байгаа нь ОУХ-ны орчин, хэлбэр, агуулга буюу ОУХ-ны систем ямагт өөрчлөгдөж байдагт оршдог болов уу. Учир нь олон улсын харилцаа нь нийгмийн болон нийгмийн бус хүчин зүйлүүдэд өртөн байнга өөрчлөгдөн хувьсахын зэрэгцээ тухайн систем дэх гол гол оролцогчид ямагт өөрчлөгдөж байдаг өвөрмөц онцлогтой билээ. Юуны өмнө **ОУХ-ны оролцогч** гэж ямар субъектийг авч үзэх талаар дор товчхон сийрүүлье.

ОУХ-ны оролцогч гэдэг нь ОУХ-ны үйл хэрэгт бие даан оролцож түүнд нөлөө үзүүлж чадахуйц улс төрийн систем буюу институт хэмээн ойлгож болох бөгөөд ОУХ-ны оролцогчийг тэмдэглэхдээ ОУХ-ны шинжлэх ухаанд гол төлөв “ACTOR”¹ хэмээх нэр томъёог хэрэглэдэг. Хэдий тийм боловч ОУХ-ны Францын сургуулийн төлөөлөгчид энэхүү нэр томъёог хэрэглэхдээ ОУХ-нд нөлөө үзүүлдэг оролцогчийг ийнхүү тэмдэглэсэн байна. “ОУХ-нд гол үүрэг гүйцэтгэн ОУХ болон бусад оролцогчдод нөлөөлж чадахуйц дурын дэглэм, байгууллага, янз бүрийн бүлэг тэр бүү хэл хувь хүнийг олон улсын харилцааны актер гэж үзэж болно”² хэмээн судлаач Ф.Брайар, М.Жалили нар үзжээ. Өөрөөр хэлбэл ОУХ болон бусад оролцогчдод нөлөө үзүүлдэг оролцогчийг “actor” буюу “оролцогч” хэмээн томъёолжээ. ОУХ-ны оролцогчийн бусад нийгмийн харилцааны оролцогчдоос ялгарах онцлог шинжүүд нь дараах байдалтай байна. Үүнд:

1. ОУХ-ны оролцогч ОУХ-нд оролцохдоо хараат бус, тусгаар, **бие даасан чадавхитай** байж, ОУХ-ны орчин дахь үйл ажиллагаанд тодорхой байр суурьтай оролцохын зэрэгцээ бусад оролцогчдод **нөлөө** үзүүлдэг байх ёстой.

2. ОУХ-ны оролцогч нь бусад оролцогчоос ялгарах өөрийн гэсэн **ашиг сонирхолтой** байх бөгөөд энэхүү ашиг сонирхлоос нь тухайн оролцогчийн үйл ажиллагааны **зорилго** нь урган гарч байх ёстой.

3. ОУХ-ны оролцогч нь өөрийн үйл ажиллагааны хэр хэмжээ, **хүч чадавхид** тохирсон ОУХ болон бусад оролцогчдод нөлөөлж чадах **арга хэрэгсэлтэй** байх ёстой.

4. ОУХ-ны оролцогч нь ОУХ-нд оролцохдоо харьцангуй тогтвортой, **системчлэгдсэн институт** маягаар оролцох ёстой.

Мөн дээрхийн зэрэгцээ ОУХ-ны зарим онолын чиглэл, сургуулиудын төлөөлөгчид ОУХ-ны оролцогчийг дараах байдлаар авч үзсэн байна. Тухайлбал:

* П.Мягмардорж- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч

Америкийн судлаач Мортон Каплан ОУХ-ны оролцогчийг 3 ангилсан.³

Үүнд:

1. National буюу Тусгаар, бие даасан улс,
2. Transnational буюу бүсийн олон улсын байгууллага. Жишээ нь: НАТО
3. Universal буюу дэлхийн хэмжээний олон улсын байгууллага. Жишээ

нь: НҮБ

Францын судлаач М.Мерль а) үндэстэн улс, б) олон улсын байгууллага, в) үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг хүчнүүдийг (Үндэстэн Дамнасан корпораци) ОУХ-ны оролцогч хэмээн тооцсон⁴ бол Ф.Брайар, М.Жалили нар М.Мерлийн ангилал дээр Үндэсний Чөлөөлөх Хөдөлгөөнийг нэмж оруулсан байна. Харин Америкийн судлаач Ж. Розенау улс, ОУХ-нд тодорхой асуудлаар бие даан оролцдог орон нутгийн засаг захиргааны нэгж, Үндэстэн Дамнасан Корпораци, мөн үндэсний чөлөөлөх хөдөлгөөн⁵ зэргийг ОУХ-ны үндсэн оролцогч гэж авч үзсэн байна.

Дээрх судлаачдын ангилал болоод ОУХ-ны оролцогчдын онцлог шинжүүдэд тулгуурлан авч үзэх юм бол <<олон улсын харилцаа болон бусад оролцогчдод нөлөөлөх чадвартай, ОУХ-нд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, өөрийн гэсэн ашиг сонирхолтой, түүнийгээ хамгаалах тодорхой хүч чадавхи бүхий харьцангуй системчлэгдсэн институтууд болох улс гүрэн, Олон Улсын Байгууллага, Үндэстэн Дамнасан Корпораци, Үндэсний Чөлөөлөх Хөдөлгөөн гэх мэт субъектуудыг олон улсын харилцааны актер буюу оролцогч>> гэж тодорхойлж болно.

Орчин үеийн олон улсын харилцааны системийн эхлэлийг 1648 оны "Вестфалийн энхий гэрээ"⁶ -гээр тавигдсан хэмээн судлаачид үздэг бөгөөд энэ үеэс шашны бус үндэсний ашиг сонирхлоо дээдэлсэн **Үндэстэн улсууд** (Nation state) ОУХ-ны үндсэн оролцогч болсон ба дэлхийн бодлого, олон улсын харилцааг тодорхойлох болсоор 20-р зуунтай золгосон билээ. Харин дэлхийн 1-р дайны дараа Парисын бага хуралд оролцогчид Версалийн гэрээг баталж энэхүү гэрээгээр Үндэстнүүдийн Холбоо⁷ хэмээх олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагааны системийг анх удаа бий болгох оролдлогыг хийж, улмаар дэлхийн 2-р дайны төгсгөлд Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдсанаар Засгийн газар хоорондын Олон Улсын Байгууллага хэмээх шинэ оролцогч олон улсын харилцаанд нөлөөлөх байр суурьтай оролцох болжээ. 1950-1970 оны үед олон улсын харилцааны онолын дийлэнх сургуулийн төлөөлөгчид олон улсын харилцааны гол оролцогчийг **улс** ба **олон улсын байгууллага** хэмээн үзэх болсон байна.⁸

АНУ-ын судлаачид болох Роберт Кеохайн, Жозеф Най нарын <<Үндэстэн Дамнасан Харилцаа ба дэлхийн бодлого>> хэмээх ном 1971 онд хэвлэгдэн гарснаар Олон улсын харилцаа дэлхийн бодлогыг судлах ОУХ-ны онолын шинэ чиглэл болох неолиберализмын урсгал гарах үндэс нь болсон. Р.Кеохайн, Ж.Най нар 1970-д оны эхэн үеийн бие даасан тусгаар улсуудын хоорондын эдийн засаг, улс төр болон нийгмийн бусад хүрээнд бий болсон

хамтын ажиллагаа “**харилцан хамаарал**” нь дэлхийн хамтын нийгэмлэгийн хөгжилд томоохон түлхэц болох бөгөөд улс, гүрэн урьдын адил СУХ-ны үндсэн оролцогч байхаа больж дэлхийн хамтын нийгэмлэгийн хүрээнд шинээр үүсэж буй харилцаануудыг бүхэлд нь хянах чадвараа алдаж байна хэмээн дүгнэжээ.⁹ Эдгээр судлаачдын үзсэнээр ОУХ-ны бүрэн эрхт субъект нь **Үндэстэн Дамнасан Корпораци, засгийн газар хоорондын бус ОУБ, хотууд, янз бүрийн үйлдвэр худалдааны газрууд** гэх мэт байж болно. Р.Кеохайн, Ж.Най нар “interdependence” буюу харилцан хамаарал нь ОУХ-г тодорхойлж байгаа үндсэн хүчин зүйл гэж дүгнэсэн бөгөөд энэхүү харилцаа: хамаарал нь эдийн засгийн салбарт хамгийн ихээр ажиглагдаж байгаа ба улсууд хоорондын эдийн засгийн харилцан хамаарал хэдий чинээ өндөр байна төдий чинээ үндэсний эрх ашиг нь хоёрдугаарт тавигдаж олон улсын хамтын ажиллагаа улам бүр нэмэгдэнэ гэж үзжээ.

Тэгвэл 1980-аад оны сүүл 90-ээд оны эхэн үеэс үзэл суртлын хоёр систем бүхий хүйтэн дайн дуусгавар болж ОУХ-ны хоёр туйлт систем задран унаснаар дэлхийн улсуудын улс төр, эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаа эрчимжин, харилцан хамаарал улам бүр нэмэгдэж 21-р зуун гарсаар Олон улсын харилцаа болон дэлхийн бодлогыг **даяаршил** хэмээх хүчин зүйл тодорхойлох болсон ба “дэлхий хавтгайрах”¹⁰ үйл явц газар авсаар байна.

Ийнхүү ОУХ-ны оролцогчдын хооронд цэрэг, улс төрийн харилцаанаас илүүтэй эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа хүчтэй явагдах болсон ба энэ хэрээр ОУХ-ны нөлөө бүхий оролцогч нь **Үндэстэн Дамнасан Корпорациуд** болон хувирч ОУХ-г маш хурдацтай өөрчилж буй нийгмийн хүчин зүйл болох даяаршлын үйл явцад гол нөлөөлөгч нь мөн л ҮДК хэмээх олон улсын харилцааны оролцогч болж байна.

Анхны ҮДК хэдийд үүссэн талаарх асуудал маргаантай байдаг ба зарим судлаачид 1118 онд байгуулагдан 1135 оноос банкны үйл ажиллагаа явуулж эхэлсэн “Орден Тамплиер”¹¹ -ыг анхны ҮДК хэмээн үздэг бол дийлэнх судлаачид 1600 оны 12 сарын 31-нд Английн хатан хаан 1-р Елизаветийн баталсан захирамжийн дагуу байгуулагдсан Британийн “Зүүн-Энэтхэгийн Компани”¹² мөн үүнээс 2 жилийн дараа байгуулагдсан Голландын “Зүүн-Энэтхэгийн Компани”-ийг жинхэнэ утгаараа анхны ҮДК байсан гэж үздэг байна.

77-ын бүлгээс (G-77) санаачилсан “Хөгжингүй орнуудын олон улс дахь монопол үйл ажиллагааг хязгаарлах тухай” асуудлаар 1972 онд НҮБ-ын хүрээнд хийгдсэн хэлэлцээрийн явцад **Үндэстэн Дамнасан Корпораци** хэмээх нэр томъёог анх хэрэглэж эхэлсэн бөгөөд НҮБ-ын тодорхойлсноор хоёр ба түүнээс дээш тооны улсад үйлдвэрлэл, үйлчилгээний салбар эзэмшиж, өөрийн үйл ажиллагаагаа явуулдаг, олон улсын худалдаа үйлчилгээ, бизнес нь түүний үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг болдог компанийг ҮДК хэмээнэ.

ОХУ-ын “Эдийн засгийн толь бичиг”-т: “хэд хэдэн улсад өөрийн салбаруудыг эзэмшдэг, тэдгээр салбаруудаар нь дамжин гол үйл ажиллагаа

нь явагддаг компани, корпорацийг ҮДК гэнэ”¹³ гэсэн бол Харвардын Их Сургуулийн судлаачдын үзсэнээр ҮДК нь дараах шалгуурыг хангасан байх ёстой ажээ. Үүнд:

- Гадаадад 6 ба түүнээс дээш **охин компани эзэмшдэг байх**;
- Хувьцаа нь олон улсад худалдаалагддаг байхын зэрэгцээ үйл ажиллагаа нь явагддаг бүхий л улсын хөрөнгийн бирж дээр **хувьцаа борлуулалт нь нээлттэй байх**;
- Компанийн дээд удирдах бүрэлдэхүүнд салбарууд нь байрладаг **улсуудын (хүлээн авагч улс) төлөөлөл орсон байх**;
- Олон улсын болон дэлхийн хэмжээнд сэтгэж чадахуйц **удирдлагын бүтэцтэй байх**;
- Өргөн хүрээнд эдийн засгийн үйл ажиллагааг явуулах боломжоор хангагдсан компанийн стратегийг үр дүнд хүргэх **байгууллагын бүтэцтэй байх** зэрэг болно.

Мөн нийт орлогын 25-30%-ийг гадаад дахь салбаруудаасаа олдог компанийг ҮДК гэнэ хэмээх тодорхойлолтыг ОХУ-ын зарим судлаачид хийсэн байдаг.¹⁴

Үүний зэрэгцээ ҮДК-ийг тодорхойлоход үндэстэн дамнасан байдлын тусгай индекс байдаг бөгөөд дараахь томъёог ашиглан индексийг тооцоолон гаргадаг байна.

$$IT = 1/3 (AI / A + RI / R + SI / S) \times 100\%$$

- **IT** – Үндэстэн дамнасан байдлын индекс, %;
- **AI** – Компанийн гадаад дахь активийн хэмжээ;
- **A** – Компанийн нийт активийн хэмжээ;
- **RI** – Компанийн гадаад салбараар дамжуулан хийж буй бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээний хэмжээ;
- **R** – Компанийн нийт бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээний хэмжээ;
- **SI** – Компанийн гадаад дахь салбарын ажилтан ажиллагсадын тоо;
- **S** – Компанийн нийт ажилтан ажиллагсадын тоо;¹⁵

ҮДК-ийг ангилахын хувьд судлаачид голчлон гурван бүлэгт хуваан авч үздэг байна. Үүнд:

- Хөндлөн нэгдэл бүхий ҮДК — янз бүрийн улсад байрлах нэг буюу ижил төрлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, мөн нэг төрлийн үйлчилгээ явуулдаг салбаруудыг эзэмшдэг корпораци.

- Босоо нэгдэл бүхий ҮДК — тодорхой улсуудад байрлах бие биендээ өөрийн бүтээгдэхүүнийг нийлүүлдэг салбаруудыг эзэмшдэг корпораци.

- Салангид ҮДК — янз бүрийн улсад байрлах хөндлөн болон босоо нэгдэл холбоосгүй салбаруудыг эзэмшдэг корпораци.

1939 онд дэлхий дээр 300 орчим ҮДК үйл ажиллагаа явуулж байсан

бол 1999 он гэхэд энэ тоо даруй 200 дахин өсөж 508,2 мянган салбар бүхий 59,9 мянган ҮДК үйл ажиллагаагаа явуулах болсон байна.¹⁶ Харин 2004 оны байдлаар 690 мянган салбарыг эзэмшдэг 70 мянган ҮДК (үүнээс толгой компанийн 73% нь хөгжингүй орнуудад, салбар компанийн 65,2% нь хөгжиж буй орнуудад байрладаг) дэлхий даяар үйл ажиллагаа явуулж байгаа¹⁷ нь энэхүү оролцогчийн тоо хэмжээ хамрах хүрээ ямар их болсныг нотлон харуулж байна.

Дэлхийн хамгийн том эдийн засгийн 51 нь ҮДК, үлдэх 49 хувь нь улсууд байгаа бөгөөд Сахараас өмнөх Африкийн нийт улсуудын (Sub-Saharan Africa) дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ АНУ-ын Женерал моторс болон Фордын ашиг орлогогч гүйцэж чадахгүй байна.¹⁸ Мөн Японы 6 том тэргүүлэх компанийн (Мицубиши, Мицуи, Сумимото г.м) ашиг орлого нь Өмнөд Америкийн бүх улсуудын ДНБ-тэй дүйж байгаа ажээ.

АНУ-ын Бодлого Судлалын Хүрээлэнгийн Глобал эдийн засгийн төслийн захирал Сара Андерсоны судалгаанаас үзэхэд ҮДК-иудын Дэлхийн эдийн засагт эзлэх хувь хэмжээ жилээс жилд улам бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 1983 онд Дэлхийн эдийн засгийн 25% -ийг ҮДК-иудын борлуулалтын орлого эзэлж байсан бол 1999 онд 27,5 % болж өсчээ.¹⁹

Дэлхийн тэргүүлэх 200 корпорацийн 82 нь (нийт корпорацийн 41% нь) АНУ-д бүртгэлтэй (толгой компани нь байрладаг) бол энэ үзүүлэлтээр 41 корпораци бүхий Япон улс 2-т жагсдаг байна.

Дараах хүснэгтээс 2011 оны байдлаар АНУ-ын тэргүүлэх 25 компанийн борлуулалтын ашиг орлогыг зарим улсуудын ДНБ-тэй харьцуулсан судалгааг харж болно ²⁰


Дэлхийн Худалдааны Байгууллага, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сангаас хийсэн судалгаа нь тодорхой улсуудын хоорондын худалдаа, бараа эргэлтийг голчлон авч үздэг боловч үнэн хэрэгтээ дэлхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 50%, дэлхийн худалдааны 70% нь ҮДК-д ногдог бөгөөд дэлхий дээр хийгдэж буй өндөр технологийн худалдааны 80%-ийг ҮДК эрхэлж, хүнсний бүтээгдэхүүний 50%-ийг үйлдвэрлэж, нийт ҮДК-иудын валютын нөөц нь бүх улсуудын Төв банканд хадгалагдаж буй валютын нөөцөөс даруй 5-6 дахин илүү байна.²¹

Дүгнэлт

Ийнхүү ҮДК-иуд нь ихээхэн хэмжээний мөнгө санхүүгийн боломжтой байдаг тул олон нийт ялангуяа улс төрийн бүлэглэлүүдэд маш ихээр нөлөөлж улмаар улс гүрэн, бүс нутаг цаашлаад ОУХ-нд өөрийн байр суурийг хүчтэй байлгаж чадаж байгаагийн зэрэгцээ дэлхийн даяарших үйл явцийг улам бүр гүнзгийрүүлж байгаа явдал нь энэхүү оролцогчийг ирээдүйн ОУХ-ны **нөлөө бүхий үндсэн оролцогч** болгох гарцаагүй дүр зураг өнөөдөр бий болоод байна.

Иймд ОУХ-ны шинжлэх ухааны судалгааны чиглэлд (дэлхийн улс төрийн

бодлогын цаашдын чиг хандлага, улс гүрнүүдийн гадаад бодлого, улсууд хоорондын харилцааны түүхэн уламжлал, өнөөгийн байдал зэргээс илүүтэй) дэлхийн эдийн засгийн цаашдын чиг хандлага, ялангуяа Үндэстэн Дамнасан Корпораци мөн Олон Үндэстний Корпорациудын (multinational corporation²²) түүх, тэдгээрийн бодлого буюу стратеги,



үйл ажиллагааны зорилго, чиглэл зэрэгт анхаарлаа хандуулах зайлшгүй нөхцөл байдал бий болжээ.

Нэн ялангуяа хөгжиж буй улсуудын эдийн засаг нь гадаад хүчин зүйлсээс, тэр дундаа Үндэстэн Дамнасан Корпорациудын (жишээ нь Рио Тинто²³) хөрөнгө оруулалтаас маш их хамааралтай байгаа бөгөөд улс төрийн шийдвэр гаргалтад ҮДК-иуд нь шууд нөлөөдөг учир Монгол мэтийн бага буурай орнын хувьд энэ талын судалгаа, шинжилгээний ажлыг маш эрчимтэй хийх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Ашигласан эх сурвалж:

Орос хэл дээр:

- Борисов А.Б. Большой экономический словарь. — М.: Книжный мир, 2003 г.
- Ланцов.С.А, Ачкасов.В.А.. Мировая политика и международные отношения. Санкт-Петербург. 2006.г
- А. И. Михайлушкин, П. Д. Шимко. Экономика транснациональной компании: Учеб. пособие для вузов. М. Высш. шк. 2005.
- Цыганков.П.А. Теория международных отношений. Москва. 2002 г.

Англи хэл дээр:

- Sarah Anderson and John Cavanagh. Top 200: The Rise of Corporate Global Power. Institute for policy Studies
- Brailar, Philippe and Mohammad-Reza Djalili. The Third World and International Relations London, 1984.
- Chambers, Clem. "Who needs stock exchanges?" Exchanges Handbook.
- Thomas Friedman. The world is flat. Farrar, Straus and Giroux. 2005
- Morton A.Kaplan. System and Process in International Politics. ECPR classics press, 2005
- Merle, M.Sociologie des relations internationales, Paris: 1974; 4th edn 1988
- Pitelis, Christos; Roger Sugden. The nature of the transnational firm. Routledge, 2000
- Richard Robbins. Global problems and the culture of capitalism. Allyn and Bacon. 1999.
- James N. Rosenau. Turbulence in World Politics: A Theory of Change and Continuity. Princeton University Press, 1990
- J.W.Smith Economic Democracy; Political Struggle of the 21st Century. M.E. Sharpe, 2000

Бусад эх сурвалж

- "Foreign policy" сэтгүүл
- George P. Smith, II Lecture delivered at Indiana University School of Law
- The Register of Letters, &c: Of the Governor and Company of Merchants of London Trading Into the East Indies, 1600-1609 Quaritch, 1893.
- 2005 оны НҮБ-ын ХХБХ-ын дэлхийн хөрөнгө оруулалтын илтгэл.
- <http://www.grandars.ru/mirovaya-ekonomika/tnk/>

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ Монгол хэлэнд үүнийг "оролцогч" хэмээн буулгах нь зөв болов уу. П.М.

² Brailar, Philippe and Mohammad-Reza Djalili. The Third World and International Relations (London, 1984). p.31

³ Morton A.Kaplan. System and Process in International Politics. ECPR classics press, 2005

⁴ Merle, M. (1974; 4th edn 1988) Sociologie des relations internationales, Paris:

⁵ James N. Rosenau. Turbulence in World Politics: A Theory of Change and Continuity. Princeton University Press, 1990

⁶ Европын улсуудын шашин хоорондын зөрчилээс үүдэлтэй 30 жилийн дайны төгсгөлд 1648 онд Европын улсуудын Оснабрюк болон Мюнстерт хийсэн энхийн хэлэлцээрийн үр дүнд байгуулсан гэрээ

⁷ League of Nations

⁸ П.А.Цыганков. Теория международных отношений. Москва. 2002 г. Стр. 230

⁹ С.А.Ланцов.В.А.Ачкасов. Мировая политика и международные отношения. Санкт-Петербург. 2006 г. Стр. 86

¹⁰ Thomas Friedman. The world is flat. Farrar, Straus and Giroux. 2005

¹¹ Ordre du Temple (францаар)

¹² The Register of Letters, &c: Of the Governor and Company of Merchants of London Trading Into the East Indies, Quaritch, 1893. 1600-1619. p.3

¹³ Борисов А.Б. Большой экономический словарь. — М.: Книжный мир, 2003. — 895 с

¹⁴ Экономика транснациональной компании: Учеб. пособие для вузов / А. И. Михайлушкин, П. Д. Шимко. — М. Высш. шк. 2005. С. 24.

¹⁵ НҮБ-ын Худалдаа, Хөгжлийн Бага Хурлаас (UNCTAD) энэхүү индексийг гаргасан байна

¹⁶ 2005 оны НҮБ-ын ХХБХ-ын дэлхийн хөрөнгө оруулалтын илтгэл. Хуудас 79

¹⁷ Мөн тэнд. Хуудас 4.

¹⁸ George P. Smith, II Lecture delivered at Indiana University School of Law—Bloomington on April 4, 2003.

¹⁹ Sarah Anderson and John Cavanagh. Top 200: The Rise of Corporate Global Power. Institute for policy Studies. 2000. December 04.

²⁰ “Foreign policy” сэтгүүл. 2012 оны 3, 4 дүгээр сарын дугаар.

²¹ <http://www.grandars.ru/mirovaya-ekonomika/tnk/>

²² Pitelis, Christos; Roger Sugden. The nature of the transnational firm. Routledge, 2000. p 72.

²³ Уул уурхайн салбарт дэлхийд 4-т бичигддэг компани